



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

21 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 315

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, хавсралтад заасан 4,452,189.07 /дөрвөн сая дөрвөн зуун тавин хоёр мянга нэг зуун наян есөн төгрөг долоон мөнгө/ төгрөгийн балансын үнэ, 1,822,716.25 /нэг сая найман зуун хорин хоёр мянга долоон зуун арван зургаан төгрөг хорин таван мөнгө/ төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг Хавдар судлалын үндэсний төвд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Захиргаа удирдлагын хэлтсийн дарга Н.Ганболд, Хавдар судлалын үндэсний төвийн ерөнхий захирлын албан үргийг түр орлон гүйцэтгэгч Н.Эрдэнэхүү нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2021 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн  
315 дугаар тогтоолын хавсралт



Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын үндсэн  
хөрөнгөд бүртгэлтэй Хавдар судлалын үндэсний төвд  
балансаас балансад шилжүүлэх автомашины жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад ороон он	Балансын үнэ (төгрөг)	Ху蕊мтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Хуандай Sonata-6, 10-67 УНҮ, арал № КМНЕТ41AP9A617393	2008/ 2008	4,452,189.07	1,822,716.25	2,629,472.82
	Нийт дүн		4,452,189.07 /дөрвөн сая дөрвөн зуун тавин хоёр мянга нэг зуун наян есөн төгрөг долоон мөнгө/	1,822,716.25 /нэг сая найман зуун хорин хоёр мянга долоон зуун арван зургаан төгрөг хорин таван мөнгө/	2,629,472.82